



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийн 17<sup>1.2</sup> дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүний амь нас эрүүл мэндийг хамгаалах осол зөрчил гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай.

1/ Гуравдугаар зүйл:

“...3.3.4...” дэх заалтыг “Импортоор оруулж ирсэн шинэ болон ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн, эсхүл экспортын дагалдах баримт бичиг, автотээврийн хэрэгслийг тухайн улсаас экспортлохын өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт” гэж.

2/ Аравдугаар зүйл:

“Автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах хэсгийн “...10.1.9...” дэх гэснийг “...10.1.10...” дахь гэж өөрчилсүгэй.

3/ Арван гуравдугаар зүйл:

“...13.2...” дахь заалтыг “Мэдээллийн сан нь төрийн үйлчилгээний болон зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн сантай холбогдож, энэхүү журмын 13.1 дэх заалтын хүрээнд харилцан мэдээлэл солилцох нөхцөл, бололцоо бүрдүүлсэн байна” гэж.

“...13.10...” дахь заалтыг “Мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн марк, загвар, хөдөлгүүр, арлын болон цахим гэрчилгээ (RFID, Smart ID, OTP, FIDO...гэх зэрэг)-ний дугаарыг латин үсгээр, бусад мэдээллийг кирилл үсгээр бүртгэнэ” гэж.

2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 10 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй.

1/ Аравдугаар зүйл:

“...10.1.8...” дахь заалтын дараа “10.1.9 Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй” гэж.

3. Журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т даалгасугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ё.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

